

ЭДИЙН ЗАСГИЙН ГЛОБАЛЧЛАЛ

Ц.БААТАР

ГЛОБАЛЧЛАЛЫН ТУХАЙ ЦУХАС ӨГҮҮЛЭХ НЬ

Саяханаас манай залуу улс төрчид, судлаачид, түүнчлэн эрдэм шинжилгээний бага хурал глобалчлалд дам болон шууд холбогдох асуудлыг хөндөн тавьж эхэллээ./1/. Түүнчлэн төвийн сонин хэвлэлүүд ч энэ асуудалд шууд болон дам холбогдох материал өргөн нийтлэх болов. Монгол Улсын төрийн тэргүүний илтгэл айлтгалд ч монголчлон тусгах боллоо. Энэ бүхнээс үүдэн зөвхөн хувийн санал бодлоо хуваалцах үүднээс холбогдох судалгааны бүтээлүүд, интернетийн сүлжээг ашиглан тус сэтгүүлд тусгай булан нээж, цуврал өгүүлэл нийтлүүлэхийг зорьж эхний хэсгийг уншигч Танаа өргөн барив. Өгүүллйг тэрлэхэд бүх талын боломж олгож интернетийн сүлжээ, ном материал ашиглах таатай боломж олгож, туслалцаа үзүүлсэн АНУ-ын Элчин Сайдын Яамны Соёл Мэдээллийн Албаны дарга хатагтай Тереза Маркив, ажилтан Цэдэндолгор, П.Тина нарт гүн талархалаа илэрхийлье.

Өнөөдөр глобалчлалын үйл явцыг дэлхийн улс орон бүр анхааралтай ажиглан харж, энэ чиглэлд судалгаа шинжилгээний ажлаа улам бүр эрчимжүүлж байгаа нь жирийн нэг тохиолдлын хэрэг биш биз ээ. Олон улсын болон төрийн бус байгууллагууд ч энэ асуудалд ихээхэн анхаарал тавих болов. Тухайлбал, Дэлхийн Банк, Олон Улсын Валютын Фондын удирдлагын дор 66 орны 185 ажлын хэсэг, 200 гаруй багууллага энэ асуудалд шууд болон дам холбогдох судалгааг олон жилийн өмнөөс явуулж эхэлсэн./2/. Канадын Засгийн газрын бус байгууллага болох Канадын Зөвлөл өдгөө 100 000 гаруй гишүүдийг эгнээндээ нэгтгэж инженерийн, хүнс, ус, агаар мандал, худалдаа, эдийн засгийн глобалчлалын асуудлаар цогц судалгаа хийж байна /3/. Олон улсад нэр хүндтэй Давид Сузукийн Фонд, Бие даасан судалгааны нэртэй төвүүд ч энэ асуудалд анхаарлаа хандуулах боллоо. /4/ Эрүүл ухаанд багтамгүй шахам асар их өргөн далайц, цар хүрээг хамран өрнөж буй энэ үйл явцтай уялдан Глобалчлалын Олон Улсын Форм (IFG) - / International Forum on Globalization/-ыг 20 гаруй орны санаачлагаар Америкийн Сан Франциско хотноо 1994 онд байгуулав. /5/ Энэ мэт глобалчлалын асуудлыг судалдаг институуд, судалгааны төвүүдийг

* Ц.Баатар - ШУА-ийн Олон Улс Судлалын Хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D)

тооловч барашгүй. Зөвхөн төлөөлөл болгож цөөхөн хэдийг дурдав. Энэ дашрамд тэмдэглэхэд «Глобалчлал» хэмээх томъёолол нь дэлхий нийтийн нийгэм-улс төр, эдийн засгийн хэллэгт байр сууриа нэгэнт эзэлжээ. Тийм болохоор дэлхий дахинаа орчуулагүйгээр хэрэглэж нэгэнт тогтсон энэ үгийн утгыг монголчлох гэж зүдрэхийн хэрэггүй болов уу. Тэгээд ч төвийн хэвлэлүүдийн бие биенээ даган моодорхон бичиж буй даяарчлал, даяаршил хэмээх томъёолууд нь глобалчлалын өргөн утга агуулга мөн чанарыг төгс илэрхийлж нэг л чадахгүй байгаа мэт санагдана. Үүнийг ухаант мэргэд болгоох биз ээ.

Өнөөгийн эринд аливаа нэг орны аж амьдралд ч тэр, нийт хүн төрөлхтөний хөгжилд ч тэр олон улсын харилцааны үзүүдэх нөлөөний хэмжээ урьд хожид байгаагүй ихээр өсөн нэмэгдлээ. Аливаа нэг улс өөрийн бодит жин, нөлөөнөөс үл шалтгаалан дэлхий нийт хамтын нийгэмлэгийн үйл хэрэгт улам бүр хүчтэй харилцан хамааралд татагдан орлоо. Дэлхийн хамтын нийгэмлэгийн геополитикийн бүтцүүдэд болон нийгэм-улс төрийн тогтолцооны хувиралд гарч буй гүнзгий өөрчлөлтүүд нь орчин үеийн дэлхий ертөнц түүхэн нэгэн үеийг туулан өнгөрүүлж, хөгжлийнхөө 100 шинэ шатанд дэвшин орсны илэрхийлэл гэж үзэх үндэстэй. Дэлхий дахины амьдрал ийнхүү хурдан өөрчлөгдөхөд хоорондоо харилцан хамааралтай таван гол хүчин зүйл нөлөөлсөн гэж судлаачид үздэг. Энэ нь нэгдүгээрт, Глобалчлал; хоёрдугаарт, Дэлхийн Худалдааны Байгууллагын /ДХБ/-ын шинэ шаардлага; гуравдугаарт, Шинэ техник, мэдээллийн технологи; дөрөвдүгээрт, Либералчлал; тавдугаарт, Хувийн капиталын урсгал зэрэг болно. Өөрчлөлтийн үйл явц нь эдийн засгийн хүрээний зэрэгцээ улс төр, нийгэм, оюун санааны хүрээг гүнзгий хөндсөнд өнөөгийн үе шатны онцлог оршино. Дээр дурдсан үйл явцын хамгийн үзэгдэхүйц илрэл, үзүүлэлт нь глобалчлал юм.

Глобалчлалын тухай анхлан америкийн эрдэмтэд дуугарсан гэж энэ чиглэлийн судлаачид үздэг. Харвардын их сургуулийн профессор Т.Левитт 1983 онд “Харвард бизнес ревью” сэтгүүлд нийтлүүлсэн өгүүлэлдээ энэ нэр томъёог анх хэрэглэсэн./6/ Тэрбээр олон үндэстний томоохон корпорациудын үйлдвэрлэж буй зарим бүтээгдэхүүний зах зээл нэгдэн нийлж, тэдгээрийн хооронд харилцан хамаарал улам гүнзгийрч буй үйл явцыг тодорхойлохдоо энэ нэр томъёог хэрэглэжээ. Харвардын бизнесийн сургуулийнхан энэ нэр томъёог улам баяжуулан өргөн утга агуулгатай болгосон бөгөөд тухайлбал, Харвардын их сургуулийн зөвлөх багш, профессор К.Омэ 1990 онд хэвлүүлсэн “Дэлхий ертөнц хил хязгааргүй болж байна” номондоо уг нэр томъёог улам бүр хөгжүүлэн сурталчилжээ. Тэрбээр одооноос эхлэн дэлхийн эдийн засаг Европын холбоо, АНУ, Япон гэсэн “гурван төвийн”

өөр хоорондын хамаарлаар тодорхойлогдох болж байна гэж үзээд тухайн нэг орны үндэсний эдийн засаг гэдэг маань өнөө утга учиргүй боллоо. Эдийн засгийн тайзан дээр “дэлхий нийтийг хамарсан пүүсүүд сайн жүжигчний дүрд тоглож байна” гэж нотолжээ. /7/ Ийм эрс нотолгоог тэр болгон бүгдээрээ зөвшөөрөхгүй байгаа ч Омэгийн байр суурь глобалчлалын сэдэвтэй холбоотой аливаа санал шүүмжлэлийн эхлэлийн цэг болсон билээ.

Зарим судлаачид орчин үеийн өөрчлөгдөн буй өнөөгийн дэлхий ертөнцөд улс орнуудын эдийн засаг, соёлын харилцан хамаарал аяндаа өргөжиж байгаа болохоос биш, ямар нэгэн тодорхой стандарт, норм хэмжээг нийтэд тулгах үйл явц байж таарахгүй учраас “интернационалчлал” гэдэг нэр томъёог хэрэглэх нь зүйтэй гэсэн санал дэвшүүлсэн байдаг. /8/. Энэ чиглэлийн гол төлөөлөгч нь мөн л Харвардын их сургуулийн профессор Д. Гэлбрейт юм. Зонхилох судлаачид үүнийг нэг л таатай хүлээж авсангүй. Тэгэхийгээд энэ санал ч цааш нэг их явсангүй. Амьдрал дээр өнөөдөр үндэстэн-төр улсууд гэж ярихын зэрэгцээ дэлхий хэмээх улс, дэлхий хэмээх нэгдмэл нэгэн “тосгон”-ы тухай их ярих болов. Яваандаа дэлхий гэдэг нэгэн “тосгон” буй болж, улс орнууд хувьцаат компани шиг, удирдагчид нь менежерүүд шиг, иргэд нь хувьцаа эзэмшигчид шиг болох хандлагатай байна. Энэ нь нэг талаар К.Омэгийн таамаглалыг баталж буй мэт.

Глобалчлал нь улс хоорондын болон үндэстэн дамнасан хэлбэрээр нэгэн зэрэг өрнөн хөгждөг хоёрдмол үйл явц юм. Ийм учраас улсууд, тэдгээрийн эвсэл, олон улсын байгууллагууд, засгийн газрын бус байгууллагууд зэрэг олон үүсгэгчтэй байдаг. Оролцогчид олонтой ч тэдгээрийн өөр хоорондын харилцаа чөлөөт өрсөлдөөний журмаар хөгжихөөр тийм олон биш байдаг. Энэхүү харилцан ажиллагаа нь цөөн оролцогчтой байдаг.

Олон улсын харилцааны шинжлэх ухаанд дэлхий дахиныг Дорно-Өрнө, Умард-Өмнөд гэсэн хэдхэн туйлтай бүтэц хэмээн ойлгож байсан хүйтэн дайны үе дууссанаар үндэстнүүд нэгдмэл болох явц эрс түргэсэв. Ийнхүү улс орнуудын өөр хоорондын харилцан хамаарал улам бүр хүчтэй болсноор НҮБ хийгээд олон улсын бусад байгууллагын тусламжтайгаар олон улсын шинэ дэг журам бүрэлдэн тогтож эхэллээ. Өнөөдөр дэлхий нийт түүнд ихээхэн найдлага тавьж байна.

Социологичид соёл түгээмэл шинжтэй болж байгаагийн нөлөөгөөр янз бүрийн орон, бүс нутгийн хүмүүсийн аж төрөх ёс ижилсэж /универсал иргэншил тийш нүүдэл хийж эхэлсэнийг/ байгааг гэрчилсэн баримтуудыг анхааралтай ажиглаж байна.

Технологийн шинжлэх ухааны төлөөлөгчид техноглобалчлал буюу тухайн орнуудад гарч буй шинэ зүйл, шинэ технологиуд техникийн

мэдлэгийн нэгдмэл цогцолбор болон нэгдэж байгаа асуудлыг, холбоо, тээвэр үйлдвэрлэлийн хүрээнд “технологийн макро систем” үүсч байгааг, харилцаа холбоо, мэдээллийн технологийн системд гарч буй хувьсгалын үр дагаврыг, Интернет бий болсныг, бүх хүмүүс “гариг ертөнцийн нэгэн “тосгон”-ы оршин суугчид болон хувирч байгааг авч хэлэлцэж байна. Энэ нэр томъёог Канадын М.Мак-Луан бүр 1962 онд санал болгосон билээ.

Парисын улс төрийн судалгааны хүрээлэнгийн профессор Б.Бади бичихдээ глобалчлалыг тодорхойлох нэгдсэн тодорхойлолт байхгүй учраас энэхүү ойлголтын олон улсын харилцааны шинжлэх ухааны үүднээс чухал гэж үзсэн гурван хэмжүүрийг онцлон авч үзэхийг санал болгожээ. Үүнд: 1. Глобалчлал гэдэг бол олон зуун жилийн турш хөгжиж буй түүхэн үйл явц юм. 2. Глобалчлал гэдэг нь дэлхий ертөнцөөрөө ижилсэж байна гэсэн үг, нэгдмэл зарчмуудаар амьдарна гэсэн үг, нэгдмэл үнэт зүйлсийг эрхэмлэнэ гэсэн үг, нэгдмэл ёс заншил, зан төрхийн хэм хэмжээг дагана гэсэн үг, бүхнийг түгээмэл болгохыг эрмэлзэнэ гэсэн үг. 3. Глобалчлал гэдэг нь өөр хоорондын хамаарал улам бүр өсөн нэмэгдэж байгааг хүлээн зөвшөөрнө гэсэн хэрэг хэмээжээ. /9/. Олонхи судлаачид үүнийг хүлээн зөвшөөрч дэмжих боллоо. Харилцан хамаарал өсөн нэмэгдэж байгаагийн гол үр дагавар нь дэлхий нийтийг хамарсан үйл явдалд шинээр оролцогчдын буюу глобал пүүсүүд, шашны бүлэглэлүүд, эрх тэгш үндсэн дээр өөр хоорондоо төдийгүй улс гүрнүүдтэй харилцан ажилладаг удирдлагын үндэстэн дамнасан бүтцүүдийн үйл ажиллагааны түрэлтэд автан тухайн улс орны үндэсний бие даасан байдал хэмээх дархлал хэврэгшин эвдэрч байгаа явдал юм. XXI зууны эхний дэлхийн хөгжлийн шинж чанарын салшгүй нэг хэсэг нь эдийн засгийн глобалчлал болов уу.

ЭДИЙН ЗАСГИЙН ГЛОБАЛЧЛАЛ

Дэлхий дахинд эдийн засгийн түгээмэл байдал улам бүр батжин хөгжиж байна. Энэ үйл явцад эдийн засгийн глобалчлал нь түүний удирдан жолоодогч систем нь боллоо. Хэрэв урьд өмнө дэлхийн эдийн засаг нь бүрэн эрхт улсууд үйл ажиллагаа явуулдаг талбар болж байсан бол одоо дэлхийн эдийн засаг улс үндэстнүүдийн талбарт үйл ажиллагаа явуулагч бие даасан субъект болон хувирлаа. Ингэхдээ үнэн чанартаа дэлхий ертөнцийн аж ахуйн организамаас илүү чухал зүйл үүсэн хөгжиж байна. Дэлхийн солбилцлын шинж чанарт болон засаг төрийн үйл ажиллагаа явуулах ердийн аргад эрс өөрчлөлт гарч, цэрэг-улс төрийн салбараас улс төр, эдийн засгийн хүрээнд шилжиж байна. Эдийн засаг нь өөрийгөө аж ахуй хөтлөх аргын талаасаа төдийгүй бас шинэ эриний улс төрийн бодлого, тэр ч байтугай үзэл суртлын асуудлыг ч

тодорхойлогч болохоо харуулж байна.

Тун саяхан болтол бид манай гаригийн эдийн засгийн орон зайг тухай тухайн орны өөрөөр хэлбэл том бага, зонхилогч болон хараат орнууд, өндөр хөгжилтэй болон сул хөгжилтэй улсуудын эдийн засгаас бүрэлддэг хэмээн ойлгож ирсэн билээ. Түүнчлэн бид улс бүхэн өөрийн аж ахуйг зохих хэмжээгээр бие даан эрхлэн хөтөлж, өөрийн хувь заяаг өөрсдөө шийдэх ёстой гэдэгт итгэлтэй байсан нь үнэхээр зүй ёсны хэрэг байв. Тэгвэл өнөөдөр дэлхийн нэг ч улс, тэр ч байтугай дэлхийн тэргүүлэгч гүрэн болох АНУ энэ утгаар өөрөө өөртөө итгэлтэй байж чадахгүйд хүрч байна. Орон тус бүрийн байдал бусад орнуудтай тогтоосон харилцаа хамтын ажиллагааны шинж чанар. ертөнц дахины үндэстнээс дээгүүрх үйл явцаар улам бүр тодорхойлогдох болж байна. Ингэхдээ улс хоорондын болон үндэстнээс дээгүүр глобалчлалаас ийнхүү хараат байх явдлын уршиг дагавар нь ХХ зууны эхэн болон дунд үед хөдөлбөргүй мэт байсан манай гаригийн улс орнуудын хөгжлийн бүдүүвч ойлголтуудтай авцалдах зүйл төдий л байхгүй боллоо.

Эдийн засгийн глобалчлал нь орчин үеийн дэлхийн хөгжлийн үзэгдлийн хувьд бүхнийг хамарсан шинж чанартай байна. Өнөөдрийн байдлаар эдийн засгийн шинжлэх ухаан үндсэн анхаарлаа дараах таван чиглэлд төвлөрүүлээд байна. Үүнд: нэгдүгээрт, санхүүгийн глобалчлал; хоёрдугаарт, олон үндэстний корпорациудын бүрэлдэлт; гуравдугаарт, эдийн засаг бүс нутгийн шинж чанартай болж байгаа явдалд; дөрөвдүгээрт, дэлхийн худалдааны илэвхжил; тавдугаарт, нэгдэн нийлэх хандлага эдгээр болно. Эдгээр тулгамдсан асуудлуудаас эдийн засгийн глобалчлалтай уялдуулан тогтож өгүүлэхийг хичээе.

САНХҮҮГИЙН ГЛОБАЛЧЛАЛ

Санхүүгийн глобалчлал нь глобалчлалын тухай санал шүүмжлэлд гол чухал байр эзэлдэг. Санхүүгийн глобал зах зээлүүд ашигтай болохыг дараах нотолгоо харуулж байна. Үүнд: үйлдвэр худалдаа эрхлэгч хэн бүхэн өөрийгөө валютын ханш, зээлийн хүү гэнэт эрс өөрчлөгдөх эрсдэлээс хамгаалах, нефть, санхүүгийн хямрал юмуу хоёр Герман нэгдсэн, саяханы Нью Йорк дахь Дэлхийн худалдааны төвийн хоёр өндрийг устгасан лалын террористуудын улс дамнасан аюулт сүлжээ гэх мэт гэнэтийн үйл явдлуудад түргэн дасах, тэрчлэн засгийн газруудаас инфляцийн бодлого, улсын өр нэмэгдэхээс сэргэмжлэх, эдийн засгийн хөгжлийг тогтвортой байлгах зэрэгт чухал ач холбогдолтой. Зах зээлийн харилцаа даян дэлхийн хэмжүүрээр ноёрхож байгаа нөхцөлд улс орнууд эдийн засгийн илүү ухаалаг стратегийг сонгон хэрэгжүүлэхээс аргагүй болж байна.

Сүүлийн арав гаруй жил эрчимжиж байгаа хил дамнасан бараа,

хөрөнгө, ажиллах хүч, мэдээллийн хөдөлгөөн олон улсын валютын зах зээлийн ерөнхий байдалд ихээхэн зөрчилтэй байдлаар / сайн болон саар талаасаа/ нөлөөлж ирэв.

Дэлхийн аж ахуйн солилцоон дахь элдэв саад тотгор аажмаар арилж байгаа нь олон улсын валют-санхүүгийн үйлдлүүдэд ихээхэн дэм болсон боловч валют-санхүүгийн механизмд урьд урьдынхаас илүү хатуу, шинэ шаардлага тавихад хүргэж байна. Түүний тасралтгүй ажиллагааг хангах явдал нь бараг дэлхийн улс бүрийн эдийн засгийн стратеги, тэдгээрийн практик бодлогын амин чухал асуудал болж байна.

Сүүлийн хагас зуун жилийн хугацаанд валютын операци асар түргэн тэлж, түүний жилийн хэмжээ 400 трилон. ам. доллар болсон байна. /10/. Санхүүгийн салбар нь глобалчлалын түвшингээрээ бодит эдийн засгийн бүх салбарыг давж гарчээ гэж олон эдийн засагчид үздэг. Энэ утгаараа санхүүгийн салбар нь дэлхийн эдийн засгийг хурдасгагч нэгээхэн чухал хөдөлгүүрийн үүрэг гүйцэтгэх боллоо. Үүний зэрэгцээ валют-санхүүгийн салбар нь эдийн засгийн үйл ажиллагааны хамгийн эрсдэлтэй хэсэг болсон бөгөөд энэ эрсдэл нь томоохон хямралд хүргэх чалвартай юм. 1998-1999 онд Япон, ЗӨА – ийн орнууд, Мексик, Бразил, Эквадор, ОХУ –ыг хамарсан хямрал бараг сүүлийн хагас зуун жилд болж байгаагүй ихээхэн цар хүрээтэй байлаа.

Сүүлийн жилүүдийн санхүүгийн хямрал нь дэлхийн эдийн засаг, зах зээл глобалчлагдснаас үүсэн гарав уу аль эсвэл тодорхой улс орнуудын хөгжилийн онцлогоос урган гарсан дотоодын үзэгдэл байв уу? Өнөөдөр ажиллаж байгаа дотоодын болон олон улсын санхүү-валютын байгууллагууд гадагшаа хөрөнгө их хэмжээгээр гарах, үнэт цаасны акшийн уналт, үндэсний валютын ханшны бууралтын асуудлыг тухайн улсын эдийн засагт хохирол багатайгаар шийдвэрлэж чадах уу? Аль эсвэл “урьдчлан сэргийлэх стратеги” өөрөөр хэлбэл, хямралаас урьдчлан сэргийлэх валют-санхүүгийн тийм стратеги хэрэгтэй болсон уу? Эдгээр асуулт амьдралаас тасархай бус бөгөөд тодорхой улсуудын эдийн засгийн бодлогыг шууд хөндөж байгаагаараа онцлогтой билээ. Энд нэг асуудлыг хөндөх зорилго тавив. Гол нь глобалчлалын үеийн дэлхийн валютын системд учирч буй бэрхшээлүүдийн тухай 1990 – ээд оны валют-санхүүгийн хямрал өмнө нь болж байсан бүх хямралаас эрс ялгаатай байлаа. Энэ “XXI зууны санхүүгийн хямралын нэг ёсны загвар” болсон бөгөөд түүний гол шалтгаан нь дэлхийн бараа таваар, санхүүгийн байдал байлаа. Нэг үгээр хэлбэл, дэлхийн эдийн засаг глобалчлагдах тутам дэлхийн санхүүгийн хямрал бусад тодорхой орнуудын зах зээлд шууд нөлөөлөх чиг хандлага энэ зуунд давамгайлах болно гэсэн үг. Чухам яагаад ийм хямрал болов гэвэл түүний үндсэн шалтгаан нь улс орнуудын дотоодын хүчин зүйлд оршиж байлаа. Ийм

хүчин зүйлүүдийн тоонд эдийн засгийг удирдах талаарх төрийн сөрөг үүрэг роль, тодорхой олигархи бүлэглэлүүдийн эрх ашгийн үүднээс хөрөнгийн хөдөлгөөнийг либералчлах түүний буруу бодлого, дэд бүцийг хөгжүүлээгүй байж хөрөнгийн зах зээлийг нээсэн болон үндэсний валютын ханшийг тогтворжуулахын тулд хиймэл бодлого явуулсан зэрэг олон зохисгүй зүйлс нөлөөлсөн.

Ийм байр суурийг академич Р.Энгов, эдийн засагч И.Королев нар хуваалцдаг бөгөөд тэдний үзэж байгаагаар 1990 – ээд оны хямрал нь олон улсын шинжтэй байгаагүй аж. /11/. Учир нь хямрал бүр тухайн орны дотоодын хүчин зүйлүүдээс шалтгаалсан байна. Тэгвэл дээрх хямрал дэлхийн өнцөг булан бүрт бараг зэрэг шахуу гарч адил төстэй үр дагаварт хүргэж, нийтлэг учир шалтгаантай байсныг юугаар тайлбарлах вэ?

Хямралын учир шалтгаан нь өнөөгийн дэлхийн санхүүгийн системд зах зээлийн болоод төрийн зохицуулалтын хоорондох зарчмын чанартай зөрчилд оршиж байгаа юм. Дэлхийн санхүүгийн систем нь төрийн зохицуулалтаас гадна, бие даасан шинж чанартай болоод байгаа билээ. Энэ нь дэлхийн хэмжээнд санхүүгийн операциуд асар ихээр хурдассан, үндэсний олон мөнгөн тэмдэгт чөлөөтэй хөрвөх болсон, евро бий болсон, мэдээллийн технологи түргэн хурдацтай хөгжсөн зэрэгтэй холбоотой юм. Дээрх зөрчлийг арилгахын тулд улс орнуудын санхүүгийн үйл ажиллагааны тухай мэдээллийг ил тод болгох, ОУВС, ДБ зэрэг олон улсын санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагааг өөрчлөн шинэчлэх зайлшгүй шаардлага урган гарч ирж байгаа юм.

Глобалчлалтай холбогдон гарч буй дэлхийн санхүүгийн зах зээл дээрх нөхцөл байдал түүнд оролцогч субъектүүдээс ихээхэн тэншвэртэй санхүүгийн бодлого явуулахыг шаардаж байна. Гэтэл тийм бодлого хараахан алга. Санхүүгийн тогтвортой байдлын төлөө хөгжингүй орнууд нэгдсэн хатуу чанд бодлого барьж байхал “хоёр дахь”, “гурав дахь” ертөнцийн орнууд, тэлгээрийн банкууд, пүүсүүд санхүүгийн хатуу дүрэм горимыг чандлан сахиж чадахгүй, тэгэхийг хүсэх ч үгүй байна. Чухамдаа ийм байдал тодорхой улс орнуудыг санхүүгийн хямралд хүргэж байгаа билээ. Чухамхүү үүнээс үүдэн өнөөгийн дэлхийн санхүүгийн байдалд сөрөг нөлөөлөл ихсэх боллоо.

Олон улсын валютын хямралын асуудалд системийн байр сууринаас хандахыг уриалагчдын тоонд Германы эрдэмтэн судлаачид орж байна. Германы эдийн засагч Р.Поль сүүлтчийн хямрал хэсэг бүлэг орныг хамарсан боловч асуудлыг системийн үүднээс авч үзэх хэрэгтэй бөгөөд хэрэг дээрээ олон улсын санхүүгийн хямралын тухай яригдаж байна гэсэн байна. Л.Хоффманыхаар бол санхүүгийн өнөөгийн хямрал нь зах зээл дээрх хөрөнгийн хэвийн бус байдал бөгөөд тэр нь гурван

хэлбэртэй ажээ. Үүнд: банкны хямрал, өрийн хямрал, санхүүгийн хямрал. Эхний хэлбэр нь банкны систем төлбөрийн чадваргүй болоход, хоёрдахь нь өр тавигчид зөвхөн банкнууд бус, төрийн байгууллагууд болж хувирсан нөхцөлд, гуравдахь хэлбэр нь мөнгөний ханшийг их хэмжээгээр буулгах, мөнгөний интервенд хийх хэлбэрээр илэрч байдаг ажээ.

Сүүлийн жилүүдийн санхүүгийн хямрал нь дээрх гурван хэлбэрийн аль алиныг агуулж байгаагаараа онцлогтой. Эдгээр гурван хэлбэр асар богино хугацааны дотор, ихээхэн хэмжээний капитал хөдөлж, мөн цаг хугацааны хувьд давхцан юуны өмнө “зах зээлд хөл тавьж буй” орнуудыг хамарчээ. Эдгээр орнууд дэлхийн санхүүгийн зах зээлийн түргэн хувьсалт өөрчлөлтөд түргэн дасах туршлагагүй нь дээр тэнд хээл хахууль газар авсан, албан тушаал буруу ашигласан зэрэг эдийн засгийн хуульд үл зохицох сөрөг үзэгдлүүд газар авсан нь мөн нэрмээс болсон байна.

Эрдэмтэн Х.Райзений үзэж байгаагаар санхүүгийн хямралыг гурван үе шатанд хувааж болдог байна. Тэрээр эхний үе шатанд 50-70-аад оныг хамруулж байгаа бөгөөд энэ үеийн хямралын гол онцлог нь мөнгөний бодлогын экстенсив шинж нь хатуу валютын курстай зөрчилдөж байсанд оршино. Хоёрдахь үе шатанд 90- ээд оны эхэн үеийн европын валютын хямралыг оруулдаг бөгөөд энэ үед Европын валютын систем нь валютын нарийн коридорын дэглэмийн нөхцөлд ажиллаж чадаагүй бөгөөд энэ үед ажилгүйдэл ихээхэн өссөн зэрэг сөрөг үр дагавр гарчээ. Гуравдахь үед 90- ээд оны сүүлийн хямрал хамаарна. /8/. Валютын хямралын тухай ярихдаа түүний үзүүлэлтийн тухай дуугүй өнгөрч болохгүй бизээ. Ийм үзүүлэлтийн тоонд Германы эрдэмтэн Х.Зиберт валютын нөөцийн хорогдол, валютын номиналь курсийн үед мөнгө, зээл хэт өргөжих, бэлэн мөнгө их хэмжээгээр үйлдвэрлэх, гүйлгээнд гаргах зэргийг оруулжээ. Ийм үзүүлэлтүүдийг боловсруулж мөрдөх нь валют мөнгөний салбар дахь хямралыг урьдчлан харах сайн талтай байдаг байна.

Оросын эрдэмтэн М.Ершов санхүүгийн хямрал системийн шинж чанартай гэдгийг мөн нотолсон бөгөөд хамгийн гол нь ийм хямрал цаашдаа давтагдахгүй байх баталгаа байна уу гэдэг асуудалд тэр ихээхэн пессимист байр суурь баримталсан. Тэр үзэхдээ дэлхийн валютын систем өргөн хүрээтэй хямралд тулж очоод байгаа бөгөөд ийм нөхцөл байдалд дэлхийн улс орнууд аль хэр оновчтой арга хэмжээ авахаас дэлхийн хэмжээний санхүүгийн хямралын үр дагаврыг бууруулж чадах эсэх нь хамаарна гэж үзэж байна. Энэ байр сууриа тэрбээр үндэслэхдээ дараах хүчин зүйлүүдэд тулгуурлажээ.

Нэгдүгээрт, дэлхийн санхүүгийн системд АНУ – ын долларын

гүйцэтгэж байгаа үүргийн өөрчлөлт. Сүүлийн 20 жилийн хугацаанд АНУ – ын долларын хөгжингүй орнуудын валютын нөөцөнд эзлэх хувийн жин ихээхэн буурчээ. / 1977 онд 99%, 1997 онд 57 %/. Нөгөөтэйгүүр дэлхийн санхүүгийн зах зээл дээрх асар их долларыг АНУ – ын эдийн засаг хямрал болсон нөхцөлд өөртөө буцааж шингээж чадах уу гэдэг асуудал байгаа.

Хоёрдугаарт, АНУ – ын эдийн засаг сүүлийн жилүүдэд ихээхэн өндөр хөгжилтэй явж ирсэн боловч дэлхийн санхүүгийн байдалд эргээд муугаар нөлөөлж байна. Ийм хүчин зүйлийн тоонд долларын хэмжээ нэг талаас, нөгөө талаас алт, мөнгөний нөөцийн хоорондын зөрөө орж байна. М.Ершовын тооцоноор бол АНУ-ын алтны нөөц нь одоо гүйлгээнд байгаа ам. долларын зөвхөн 3 хувийг хангахаар байгаа ажээ.

Цаашилбал, эдийн засагт хямд долларын тариа хийгээд байх нь цаашдаа АНУ –д биш гэхэд бусад оронд мөнгөний ханш унах дэлбэрэлтэд хүргэж болох ажээ. Үүний тодорхой жишээ бол ЗӨА – ийн санхүүгийн хямрал юм. Түүнчлэн ам. долларын ханш унах магадлал их бөгөөд учир юу вэ гэвэл “Голдман-Сакс” банкны үзэж байгаагаар 1998 оны эцэст ам.доллар йений хувьд 25% - иар илүү, Германы маркийн хувьд 15 % иар илүү үнэлэгдсэн байх жишээтэй. /12/. Олон улсын банк-санхүүгийн ирээдүйн хямралаас гарах, түүнээс урьдчлан сэргийлэх арга механизмыг эдийн засагчид, санхүүгийн мэргэжилтнүүд өдгөө эрсээр байна. Ийм арга замын тоонд дэлхийн өндөр хөгжилтэй 8 улсын төр, засгийн тэргүүн нарын дэлхийн санхүүгийн байдалд хяналт тавих механизмыг боловсронгуй болгохоос эхлэх ёстой гэсэн бодол зонхилж байна. Үүний тулд эдгээр улсууд дотоод эдийн засгийн бодлогоо хоорондоо зохицуулахаас эхлэх ёстой. Энэ үндсэн дээр олон улсын санхүүгийн чухал асуудлаар нийтлэг байр суурь, чиг хандлагад хүрэх ёстой аж. Дотоодын гэдэг ойлголтод ДНБ – ий өсөлт, инфляцийн түвшин, процентийн хувь, төсвийн болоод худалдааны тэнцэл, валютын курс зэрэг ойлголтууд орж байна. Дараагийн шатны зорилго бол, “ удирдлага бүхий глобалчлал” – ын тухай ойлголтыг дэлгэрүүлэх асуудал юм. Энэ нь глобалчлалын үйл явцыг урсгалаар нь орхих бус түүнийг нарийн бодлоготойгоор залж чиглүүлэхэд оршино. Үүнд олон улсын байгууллагууд чухал үүрэгтэй. Эдгээр байгууллагуудын тоонд ОУВС, ДБ орох бөгөөд эдгээрийн үйл ажиллагааг үндсээр нь эргэж харах цаг болсон байна. Дурдсан байгууллагуудын үйл ажиллагаа өнөөгийн глобалчлалын эрин үеийн шаардлагаас ихээхэн хоцрогдож байгааг дэлхийн олон орны мэргэжилтнүүд, шинжээчид, судлаачид төдийгүй, засгийн газрууд ч ойлгон тэмдэглэж байгаа. Глобалчлалын эсрэг дэлхий дахинаа өдгөө өрнөж буй өргөн хөдөлгөөн ч үүнийг нотолж байгаа билээ. Удаах чухал арга хэмжээ бол үндэс дамнасан корпорациудын

үйл ажиллагаанд хяналт тавих явдал болж байна. Тухайлбал, эдгээр корпорациудын үйл ажиллагааны кодексийг боловсруулж мөрдүүлэх нь чухал. Өөрөөр хэлбэл, хөрөнгийн шилжилт, хөдөлгөөнд хязгаар тавих, нэн ялангуяа богино хугацааны хөрөнгийн шилжилтэд онцгой анхаарах, валютын ханшны бодлогод шинэ “зангууны” /оросоор якорь гэдэг” зарчим баримтлахын чухлыг судлаачид тэмдэглэх боллоо. Үүний уг санаа нь дэлхийн томоохон хөрвөдөг валютыг – евро ч юмуу, иен, доллар ч юм уу /үндэсний валютын/ ханшийг тогтоохдоо нягт уялдуулан зохицуулахыг хэлж буй хэрэг. Шинэ “зангууны” бодлогыг хэрэгжүүлэх нь санхүүгийн тогтвортой байдлыг дээшлүүлэх, холбогдох орнуудын эдийн засгийн удирдлагыг боловсронгуй болгох, тэргүүлэгч валютын үүрэг ролийг дээшлүүлэх зэрэгт чухал ач холбогдолтой. Колонийн үеийн Бруней, Жибути, мөн өнөөгийн Эстон, Гонконг, Аргентин ийм аргыг өргөн хэрэглэж байгааг үүнтэй холбогдуулан дурдаж болох юм.

Дээрх аргыг хэрэглэхэд урьдчилсан нөхцөл бүрдсэн байх ёстой. Тухайлбал, зангуу гэгдэх улстай эдийн засгийн нэг орон зайд байх, эдийн засаг ихээхэн нээлттэй байх, эдийн засаг нь хэмжээгээрээ жижиг байх зэрэг шаардлагууд ордог.

ЭДИЙН ЗАСГИЙН ОРОН ЗАЙН ГЛОБАЛЧЛАЛЫН НӨХЦӨЛ ДЭХ ҮНДЭСТЭН ДАМНАСАН КОРПОРАЦИ

XIX зууны төгсгөлд орон нутгийн эдийн засгийн систем нь үндэсний эдийн засгийг бүрдүүлж ирсэн. Харин XX зууны сүүл, энэ зууны эхээр үндэсний эдийн засаг дэлхийн эдийн засагт уусах үйл явц эрчимтэй өрнөж буйгаараа ихээхэн онцлогтой. Үүнтэй холбогдон улсуудын хоорондын харилцан хамаарлын цоо шинэ хэлбэр бий болж эхэллээ. Энэ үйл явц Өрнөдийн өндөр хөгжилтэй орнуудад үүсэн орон зайгаа тэлсээр буй мэдээллийн технологийн хөгжилтэй салшгүй нягт холбоотой.

Өдгөө дэлхийн эдийн засгийн орон зайн араг яс нь үндэстэн дамнасан корпорациуд болоод байна. Эдгээрийн дотоодын үйл ажиллагаа нь төлөвлөгөөгөөр зохицуулагддаг. Үүний дүнд дэлхийн эдийн засгийн дөнгөж дөрөвний нэг нь чөлөөт зах зээлийн нөхцөлд явагдаж буй. Зах зээл, төлөвлөгөө хоёрын хооронд нэгдэн нийлэх зайлшгүй үйл явц эрчимтэй өрнөж байна. Ингэснээр өөрийн гэсэн геостратегийн сонирхол бүхий үндэстэн дамнасан корпорациудын ертөнц бий болж байна. Энэхүү шинэ ертөнцийн валютын нөөц дэлхийн бөмбөрцгийн бүх улсын төв банкнуудын валютын нөөцөөс даруй 5-6 дахин их болжээ. /13/. Үндэстэн дамнасан хөрөнгө капиталын хэмжээ ийнхүү асар ихээр өргөжин тэлж байгаа нь улс орнууд өөрсдөө бие даан дотоодынхоо санхүүгийн зах зээлийг зохицуулах ямар ч

найдлагагүй болгож байна. Бий болсон энэ нөхцөл байдалд Кейнсийн болон монетарист аргууд түүхэн үеэ өнгөрөөж нэгэнт хоцрогджээ. Ийм нөхцөл байдалд үндэсний улсуудын үүрэг роль хоёрдугаар зэрэгт орж, ҮДК – ийн үйл ажиллагаа үндэсний улсуудын эрх мэдлийн хүрээнээс хальж гарав.

ҮДК – уудын хөгжлийн дүнд дэлхийн эдийн засаг өөрийгээ өөрөө нөхөх цорын ганц систем болж, эдийн засаг дахь дээд эрх мэдэл үндэсний хэмжээнээс глобал хэмжээнд халин гарч, гагцхүү дэлхийн зах зээл л салбар хоорондын, бүс хоорондын нөхөн үйлдвэрлэлийн хэмжээ хязгаарыг зохицуулах чадвартай болохоо батлан харууллаа.

Өмнө нь бараг бүх улсын аж ахуй өөрийгээ өөрөө нөхөн үйлдвэрлэх чадвартай байлаа. Тэгвэл өнөөдөр ийм зүйлийг дэлхийн эдийн засаг л хийх чадвартай. Өнөөдөр үндэсний ямар ч эдийн засаг ганцаараа нөхөн үйлдвэрлэл явуулах чадваргүй болжээ. Энэ байдлын улмаас хүн төрөлхтний хөгжлөөс ерөнхийдээ хоцорч яваа улсууд цаашдаа бие дааж хөгжих ямар ч ирээдүйгүй, гарцгүй замд орлоо хэмээн балмагдан цочирдож глобалчлалд хамаг бурууг тохон түүнийг элдвээр эсэргүүцэх боллоо.

Глобалчлалын үйл явцын зэрэгцээ мөн бүсчлэл, задралын үйл явц явагдаж байгааг хэлэх хэрэгтэй. Үндсэндээ эдгээр үйл явц глобалчлалын дүр төрхийг бий болгож байгаа юм. Гэвч глобалчлалын эсрэг үйл ажиллагаа ч хаа сайгүй явагдаж байна. Гэхдээ эл эсрэг үйл ажиллагаа зах хязгаарын /периферийный характер/ шинжтэй юм. Нэг талаас глобалчлалын үйл явц аяндаа хөгжиж нөгөө талаас газрын биодавхаргааны нөөц баялгийг ашиглах үйл явц эрчимтэй өрнөж, байгаль ертөнц өөрийгээ нөхөх чадваргүй болжээ. Дэлхийн дулааралт хурдассаар байна. Дэлхийн дулааралтыг зогсоох нэг нөхцөл болсон нүүрсхүчлийн хийн ялгаралтыг яаж багасгах вэ гэдэг асуудал дэлхий нийтийн санааг зовоосоор буй билээ. Японы эрдэмтэд энэ чиглэлд уйгагүй эрэл хайгуул хийж байгаа хэдий ч энэ нь туршилтын шатандаа явна. Намгийн хий, идэвхжүүлэх катализатор хоёрыг ашиглан 97%-ийн цэвэршилттэй нүүрстөрөгчийг гарган авч болох Саппоро-пиво болон Шимадзүгийн үйлдвэрийн ноу хау практикт нэвтэрдэгийн даваан дээр байна. Гэсэн хэдий ч энэ нээлт амьдралд нэвтэртлээ зохих хугацаа туулах биз ээ. Түүнчлэн дэлхийн бөмбөрцгийн “уушиг” болсон Сибир, Бразилийн ой модны нөөц дуусаж, өөрийгөө нөхөх боломжгүй болж эхэллээ. Нүүрс хүчлийн түлшний бүтээгдэхүүнийг дахин боловсруулах боломж хараахан алга. Атомын цахилгаан станцуудын хаягдлыг дахин боловсруулах асуудал өнөөг хүртэл шийдэгдээгүй байна. Эрчим хүчний “гурав дахь” эх үүсвэр олох оролдлого одоохондоо амжилтад хүрээгүй байна. Үүн дээр экологийн болоод хүн амын

холбогдолтой олон асуудлыг нэмэх хэрэгтэй юм. Эдгээр асуудлыг шийдвэрлэх эдийн засгийн арга олдоогүй нөхцөлд глобалчлал захиргаадалтын “тоталитар” маягийн шинжтэй болж болзошгүй.

МЭДЭЭЛЛИЙН ГЛОБАЛЧЛАЛ

ҮДК – уудын ертөнц өөрийн гэсэн мэдээллийн сүлжээтэй. Глобалчлал, ҮДК мэдээлэлжүүлэх үйл явцтай зэрэгцээ явагдсан бөгөөд түүний биет үндэс нь дэлхий нийтийн мэдээллийн систем, түүний дотор интернет байлаа. Энэ бүхэн нийлээд дэлхийн мэдээллийн кибер – орон зайг бий болгосон билээ. Үүний дүнд хүн-машины нийгэм бий болж хүний нийгмийн бүхий л институтууд өөрийн үйл ажиллагаагаа мэдээлэлд тулгуурлан явуулах боллоо. Түүнчлэн өнөөдөр худалдаа, наймаа ерөөс хүний өдөр тутмын үйл ажиллагаа гагцхүү мэдээлэлд тулгуурлаж байна.

Капитал, хөдөлмөр хоёр сүлжээнд /мэдээллийн/ тулгуурлах болов. Энэхүү сүлжээ хөрөнгө, ажиллах хүч, шинжлэх ухаан-техникийн үйлчилгээг бүхэлд нь захиран зохицуулж эхэллээ. Сүлжээний морфологи нь хөрөнгийн бирж, үндэстэн дамнасан банкны үйл ажиллагаанд тулгуурлан санхүүгийн технологийн тоглоомын дүрмийг зохиож, санхүүгийн зах зээлийн либералчлалыг бүрмөсөн удирдах болсон байна.

Мэдээллийн глобалчлал соёлын салбарт ч мөн нэвтрэн орж байна. Соёл бол хүн төрөлхтний оюун санааны эхлэлд үндэслэдэг гэдэг. Гэтэл өнөөдөр энэ байдал өөрчлөгдөж оюуны санааг цэвэр технологийн эхлэл орлож эхэллээ. Үнэн хэрэг дээрээ мэдээлэл-санхүүгийн олиграхи үүсч олон улсын олигархийн дэглэм бий болох нөхцөл байдал үүсчээ. Энэ нь ардчлалын засаглалын оронд ардчлалын дараах мөнгөний засаглал бий болох нөхцөл байдлыг бүрдүүлэв.

Сүлжээний /компьютерийн/ ертөнцөд засаглалын шат дараалал гэж байхгүй тул ихээхэн тогтворгүй, тиймийн дээрээс хямралд өртөмтгий юм. Ухаандаа компьютерийн ертөнцөд нийт дэлхий дахины засгийн газархуу нэг төв гэж байхгүй. Энэ нь дэлхий дахины тоталитар дэглэм өөрөөр хэлбэл, АНУ тэргүүтэй “алтан миллиардын” засаглал бий болгох зам мөн юм. Нэг үгээр хэлбэл сүлжээний глобалчлал нь хүн төрөлхтний амьдралд чанарын шинэ өөрчлөлтүүд орууллаа. Энэ нь хүн төрөлхтний нийгэм аж үйлдвэрийн дараах шатанд нэгэнт орсныг илтгэн харуулж буй хэрэг.

2002 он гэхэд Интернет хэрэглэгчдийн тоо нэг тэрбумаас давах бөгөөд түүнийг бизнесийн зорилгоор ашиглагчдын тоо 300 саяд хүрэх аж. /14/. Сүлжээний асуудлаар АНУ –д хийсэн судалгаанаас үзэхэд компьютерийн сүлжээ хэрэглэгчдийн сэтгэл зүй нэгээс хоёрхон жилийн дотор эрс өөр болоод зогсохгүй тэдний зан чанар хүртэл өөрчлөгддөг болохыг тогтоожээ. Тийм учраас сүлжээ ашиглагчид бодит амьдралд

дургүй дан ганц компьютер дэх хийсвэр, зүүдний ч юм шиг ертөнцөд илүү дуртай болдог байна. Түүгээр ч барахгүй уур удаартай нэгэн болдог аж. Залуу хүмүүс орон зайн болон цаг хугацааны ямар нэг төсөөлөлгүй болж өөрийн сэтгэл санаа, ааш араншинг удирдах ямар ч чадваргүй болдог байна. Өөрөөр хэлбэл ааш араншин, сэтгэл санааны хувьд компьютерийн бүрэн хараат байдалд орсноороо сүлжээний эрх чөлөөгүй байдалд хүрдэг. Цөөхөн үгээр хэлбэл байгалийн бүтээгдэхүүн – хүн машин, аппарат хэрэгслийн нэг төрөл болон хувирдаг байна.

Компьютерийн сүлжээний технологи дээрхийн нэг жишээ байна. Хэрэглэгч гурван зүйлд турлгуурлан компьютер хэрэглэдэг. Үүнд: монитор, компьютерийн гар /клавиатура/ мөн компьютер ашиглах өөрийн дадлага. Гол тархи, бусад хавсралт мэдээлэл компьютерийн сервер дотор байдаг. Харин сүлжээний эзэн бол уг сүлжээг ашиглагчийн хувьд бүрэн хяналт тавьдаг бөгөөд сүлжээг бүрмөсөн таслах ч эрхтэй. Дэлхий дахины холбооны систем цөөн улсын гарт төвлөрч бүх мэдээллийг хянаж байдагт хэргийн учир оршино. Энд нэг хэсэг нь эрх чөлөө эдэлж нөгөө хэсэг нь эрх чөлөөгүй байдалтай байгаа нь тодорхой харагдаж байгаа биз. Мэдээллийн глобалчлалын сөрөг тал гэж үүнийг хэлнэ.

Сүлжээний глобалчлалын тухай ярихдаа хар тамхи наймаалагчид, зэвсгийн наймаа эрхлэгчид, террористуудын глобал сүлжээг ч мөн дурдаж болно.

Глобал сүлжээнд дэлхийн олон орон шинээр татагдан орсоор байна. Глобал сүлжээний цаашдын тархалтад саад тогтор учруулах хүч дэлхий дээр байхгүй. Глобал сүлжээ дэлхий нийтийн тоталитаризмийг бий болгох ёс зүй-сэтгэл санааны бэлтгэлийг хангаж, түүнийг нэг төвөөс удирдах нэг ёсны хэрэгсэл, дэд бүтцийг бий болгож байна.

Ийнхүү “олон улсын мөнгө, санхүүгийн тогтворгүй байдал нь санхүү, мэдээллийн глобалчлалын өөрийнх нь гол онцлог шинж” болж байна. /15/. Ийм учраас дэлхийн хэмжээгээр зохицуулалт хийх нэмэлт арга хэрэгсэл зайлшгүй чухал болох тухай асуудлыг эрдэмтэн судлаачид байнга дэвшүүлэн тавьсаар байгаа боловч энэ чиглэлд ямар нэг дорвитой ахиц өөрчлөлт өнөө хэр хараахан гараагүй байна.

ЭДИЙН ЗАСГИЙН ГЛОБАЛЧЛАЛЫН НӨХЦӨЛ ДЭХ ДЭЛХИЙН ХУДАЛДАА

Глобалчлалын үйл явц, хөгжлийн эрч хүч түүний түрэлт нь тун хачирхалтай мэт нөхцөл байдлыг бүрэлдүүлж эхэллээ. Олон жилийн турш дэлхийн худалдааны солилцоо дэлхийн хэмжээний үйлдвэрлэлээс түргэн нэмэгдэж байна. 1997 онд дэлхий дахинд дотоодын нийт

бүтээгдэхүүний хэмжээ 3 хувь өсчээ. Энэ бол өнгөрөгч арван жилийн аливаа үзүүлэлтээс давсан томоохон өсөлт юм. Гэтэл дэлхий дахины таваарын экспорт 1997 онд 9,5 хувь өсч, үйлдвэрлэлийн өсөлтийн хурдлаас 3 гаруй дахин давсан байна. /16/. Тун саяхан болтол нэг үндэстэн улсын хүрээнээс хальдаггүй байсан олон улсын үйлчилгээний худалдаа бүр ч түргэн өсч байна. Энэ бол бас шинэ үзэгдэл юм. 1980-1997 онд өргөн хэмжээний үйлчилгээний арилжаа бараа таваарын худалдаанаас хоёр дахин хурдан өсч, жил тутам 9 хувиар нэмэгдсэн байна. Энэ нь 1995 онд дэлхийн худалдааны нийт хэмжээний бараг дөрөвний нэгийг эзэлсэн юм. Өнгөрсөн онд энэ үзүүлэлт буурсангүй харин ч өсчээ.

Америк юмуу Японы дэлгүүрүүдийн лангуу Зүүн Өмнөд Ази, Латин Америкийн бараагаар дүүрсэн байхыг хараад нэг их гайхах хэрэггүй.. Жишээ хэлэхэд, АНУ юмуу Японд үйлдвэрлэсэн зургийн аппарат, магнитофон худалдан авахад маш хэцүү. Нэр нь дандаа хамгийн нэр хүндтэй пүүсүүд буюу “Сони”, “Панасоник”, “Пентакс”, “Кодак” –ийн барааных байдаг. Тэгвэл үйлдвэрлэсэн газар нь Сингапур, Таиланд, Өмнөд Солонгос, Хятад байна. Тухайн барааг чухам хаана үйлдвэрлэсэн нь хамаагүй, чанарыг пүүс нь хариуцна гэж худалдагч тайлбарладаг. Энэ бол глобалчлалын шинж тэмдэг. Тодруулбал ажиллах хүчин хаана хямд байна үйлдвэрлэлийг тэнд өрнүүлэх хэрэгтэй гэсэн жишиг нэгэнт тогтжээ.

Хил хязгаар нь худалдааг цаашид саатуулахаа больжээ. Зөвхөн өөрийн “түүхэн эх оронд” уяатай байхаас татгалздаг үйлдвэрийн газрууд улам бүр олширсоор байна. Сүүлийн арван жилд гадаадал оруулсан шууд хөрөнгө оруулалтын өсөлт дэлхийн худалдааны хэмжээний өсөлтөөс гурав гаруй дахин давжээ. Үүнтэй уялдан капиталын тодорхой нөөц юмуу үйлдвэрлэлийн баазыг мөнхөд эзэмшиж байх болно гэж нэг ч орон найдах аргагүй болжээ. Жишээлбэл нэхмэлийн аж үйлдвэрийн үйлдвэрийн газрууд тухайн цагтаа баруун Европын орнуудаас гарч, өсөн өндийх шатандаа орсон Азийн эдийн засгийн “баруудыг” сонгосон билээ. Сүүлийн үед элгээр оронд ажиллах хүчний өртөг өссөн учир шилжилт дахин сэргэв. Зөөлөн оёдол мэт нь Монголд байршиж амжлаа. Тэд Монголын хямд ажиллах хүчинд цагийн 50 цент ч хүрэхтэй үгүйтэй цалин өгч байгааг бид бэлээхэн мэднэ.

Сүүлийн жилүүдэд гадаадын шууд хөрөнгө оруулалт түргэн өсч, түүнийг олон улсын хэмжээнд зохицуулах оролдлого илэвхижсэн нь хөрөнгө оруулалт болон гадаад худалдааны хоорондын харилцан холбооны асуудалд тусгалаа олж байна.

Гадаадын шууд хөрөнгө оруулалт, гадаад худалдааны аль

нь эдийн засгийн байдал, түүний хөгжлийн хэтийн төлөв, өсөлтийн хурдацад асар их нөлөө үзүүлж байна. Энэ хоёрын салшгүй харилцан холбоо нь дараахи зүйлээр илэрч байгаа нь эргэлзээгүй юм:

- эдийн засгийн өсөлтийн хүчин зүйл болох гадаад худалдааны үүргийг ямагт хүлээн зөвшөөрч ирсэн нь гадаад худалдааны аль нэг бодлого явуулахад илэрч байв. Шууд хөрөнгө оруулалт нь гадаадын зах зээлд бараа таваар, үйлчилгээ нийлүүлэх гол хэрэгсэл, олон улсын үйлдвэрлэлийн системийн гол нуруу болсноор дэлхийн худалдааны цар хэмжээ, чиглэл, бүтцэд улам ихээр нөлөөлж байна. Ийм нөхцөлд гадаадын шууд хөрөнгө оруулалтын зохицуулалт ч худалдаанд зайлшгүй нөлөөлдөг;

- дэлхийн улам олон орон эдийн засгийн хөгжлийн үйл явцад гадаадын шууд хөрөнгө оруулалт нааштай үүрэг гүйцэтгэлийг хүлээн зөвшөөрч байгаа бөгөөд энэ нь гадаадын хөрөнгө оруулалтын талаар тэдгээрийн баримтлаж буй бодлогоор илэрч байна. Үүний зэрэгцээгээр, гадаад худалдаа, гадаад эдийн засгийн бодлого гадаадын шууд хөрөнгө оруулалтын урсгалын цар хэмжээ, чиглэл, бүтэцэд нөлөөлдөг;

- эдийн засгийн хөгжилд гадаадын хөрөнгө оруулалт, гадаад худалдааны оруулах хувь нэмрийг хамгийн их болгохын тулд эдгээрийн харилцан үйлчлэлийг хангаж, өөрөөр хэлвэл тэдгээрийг нэгдмэл нэг бүхэл бүтэн зүйлийн хувиар ашиглах хэрэгтэй.

Тийнхүү, гадаадын шууд хөрөнгө оруулалт болон гадаад худалдааны харилцан холбооны утга, агуулгыг тодорхой ойлгох хэрэгтэй. Одоо болтол гадаадын хөрөнгө оруулалтын талаархи бодлого, гадаад худалдааны бодлогыг бие биеэс нь хараат байдлаар боловсруулж байгаа нь эдгээрийн тус бүрийнх нь зорилгыг харилцан зөрчилдүүлж, хэрэгжүүлэх үр нөлөөг бууруулж байна. Олон улсын эдийн засгийн харилцааны хоёр суурь хүрээний харилцан шүтэлцээг тодорхой ойлгох нь үндэсний хэмжээнд хэрэгжүүлж буй бодлогыг боловсронгуй болгоход ч, худалдаа, хөрөнгө оруулалтыг улс хоорондын хэмжээнд зохицуулахад ч чухал ач холбогдолтой. Энэ асуудал Монгол улсад ч нэгэн адил хамаарна.

Сүүлийн гурван жилд дэлхийн худалдаа өндөр хурдацтай өсч байна. Жишээ нь 1996 онд түүний эргэлт 4%-иар, 1997 онд бүр 9%-иар өсчээ. Үндсэндээ энэ нь Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын орнуудын дотоодод худалдаа өргөжсөнийүр дүн болсон бөгөөд тус байгууллагад өсөлт 6,5-аас 11% хүртэл өсч, түүнчилэн боловсруулах аж үйлдвэрийн бүтээгдэхүүний худалдаа 7-гоос 17% болж өссөн байна. Сүүлийн таван жилд дэлхийн худалдаанд энэ

байгууллагын эзлэх хувь хэмжээ 71-73%-ийн түвшинд тогтвортой байна./17/. Дэлхийн зах зээлд Зүүн өмнөд Азийн орнуудын, түүний дотор “хоёр” дахь үеийн шинэ үйлдвэржсэн орон – Индонез, Филиппин, Малайз, Таиландын зүгээс давшилт хүчтэй болж байна. Азийн хоёр томоохон орон – Энэтхэг, Хятадын байр суурь бэхжиж байна. Хөгжиж буй орнуудын хоорондын худалдаа түргэн өсч байгаа нь 90-ээд оны мэдэгдэхүйц үзэгдэл болов. Дэлхийн худалдаанд Азийн хувь хэмжээ (Японыг оролцуулахгүйгээр) Умард Америкийн хэмжээнээс давж, цаашид нэмэгдсээр байна.

Азийн шинэ экспортлогчид үндсэндээ Өрнөд Европын орнуудын ачаар дэлхийн худалдаанд байр сууриа хүчтэй болгож байна. Энэ нь хөгжиж буй орнуудын хувьд уламжлалтай нэхмэл болон хэрэглээний зориулалттай өөр харьцангуй энгийн бүтээгдэхүүний зах зээлд төдийгүй, үйлдвэрлэлийн хэрэгслийг оролцуулан нарийн үйлдэхүүний зах зээлд болж байна.

1991-1997 онд дэлхийн худалдааны эргэлтэд Европын холбооны хувь хэмжээ 43-44-өөс 36-40% болж буурч, харин Ази-Номхон далайн бүс нутгийн орнуудынх 38-39-өөс 44-42% болж өссөн байна. 1997 онд дэлхийн худалдааны эргэлтэд ТУХН-ийн эзлэх хувь хэмжээ 2% жаахан илүү байна. /18/. Дэлхийн худалдаанд тэнцвэргүй байдал хэвээр байна. Ойрын жилүүдэд эдийн засгийн мөчлөг хөгжил болон дэлхийн санхүүгийн зах зээлийн хямрал үзэгдлийн ялгаанаас болоод энэ тэнцвэргүй байдал ихсэх хандлага давамгайлах болов уу.

Эдийн засгийн глобалчлал нь тухайлбал үйлдвэрлэл гадаадад шилжих шалтгааны дотор үйлдвэрлэлийн зардлын багасалт улам их үүрэг гүйцэтгэж байна. Энэ нь барааны урсгалын тоог нэмэгдүүлж байна.

Шинжээчддийн үзэж байгаагаар, хэтдээ дэлхийн худалдаанд Хятад (Гонконг, Тайванийн хамт), БНСУ, Таиланд, Малайз, Филиппин, Энэтхэг, Африкийн өмнөд нутгийн орнууд, Польш, Турк, Мексик, Бразил, Аргентин, Оросын үүрэг онцгой мэдэгдэхүйц болно. “Шинэ том зах зээл” гэсэн ойлголтод нэгдсэн эдгээр орон үлэмж хэмжээний нутаг дэвсгэр, хүн амтай юм. Эдгээр нь эдийн засгийн эрс өөрчлөлт хийж, дэд бүтцээ хөгжүүлж, их эрэлт хэрэгцээтэйн гадна, экспортоо нэмэгдүүлж байна. Ингэхдээ эдгээр орны эдийн засаг нэлээд нээлттэй байгаа нь тэдний эдийн засгийн өсөлт дэлхийн худалдааны хөгжилд их нөлөө үзүүлнэ хэмээн таамаглах боломж олгож байгаа юм.

Харилцаа холбооны өртөг буураагүй бол глобалчлалын үйл явц түргэн хурдацтай өрнөх бололцоогүй байсан юм. Харилцаа холбооны өртөг буурсны дүнд их зардал чирэгдэл гаргалгүйгээр дэлхий

дахинтай дуртай цагтаа харьцах бололцоо бий болсон юм. Интернетийн сүлжээ шиг глобалчлалын зарчмыг тодорхой, дөхөм ойлгоштой харуулдаг хэрэгсэл хаана ч байхгүй. Чухамдаа дээрх байдал л дэлхийн худалдааны чөлөөт урсгалыг улам бүр хурдасгасан гэхэд нэг их хэтрүүлэг болохгүй биз ээ.

1998 онд болсон дэлхийн эдийн засгийн глобалчлалын асуудлаархи Монреалийн бага хурал дээр Канадын Шинэ ардчилсан намын тэргүүн Алекса Макдоноу үг хэлэхдээ, “Өнөөдөр, коммунизм сүйрэн унаснаас хойш арван жилийн дараа үйлдвэрийн эдийн засгийн бодитой ололт нь гагцхүү капиталын аюулгүй байдлыг хангасан явдал болов. Одоо чөлөөт капитализм манай эриний эдийн засгийн зонхилох хүчин болсон тийм нөхцөл байдалтай, сая сая хүмүүсийг зориуд хөдөлмөрлөх бололцоогүй болгодог тийм бодлоготой өнөөдөр бид тулгараад байна. Глобалчлал зөвхөн ашиг олоход тулгуурлаж байгаа бөгөөд өөрийгөө хөнөөх хүчин зүйл болж байна. Глобалчлалын өнөөгийн загвар нь ичгүүргүй шударга бус явдал юм, энэ нь төрийн үнэт зүйлсийг ч нийгмийн тэнцвэрийг ч алдагдуулж байна” гэжээ.

Глобалчлалаас аж үйлдвэрийн талаар хөгжингүй баян орнууд гол ашгийг олж байна. Чухам тэдгээр орон нарийн технологи бүхий бүтээгдэхүүн үйлдвэрлэхийг дагнаж, хөдөлмөр их зарцуулдаг, нэгэн хэвшил болсон технологийн процесс хэрэглэдэг таваарын үйлдвэрлэлийг хямд ажиллах хүчин бүхий шинэ тулгар орнуудын нуруунд үүрүүлж байна. Үүний уршгаар тийм барааны харьцангуй үнэ дэлхийн зах зээл дээр унаж байна. Энэ нь тийм таваар импортлодог хөгжингүй орнуудад ашигтай юм. Яагаад гэвэл тэдгээрийн хувьд худалдааны болзол гэгч нь эрс сайжирч байгаад оршино. /экспортын хийгээд импортын үнийн хоорондын харьцаа/ “Азийн эрчимтэй хөгжиж буй орнууд”. “Дорнод Европын хуучин коммунист орнууд глобалчлалын үйл явцад улам бүр гүнзгий татагдан орж байна” гэж Баварын хүрээлэнгийн профессор Норман Бертольд тэмдэглэжээ. Дэлхийн эдийн засагт шинээр оролцогчид нь мэргэжил багатай ажиллах хүчин ашиглан үйлдвэрлэдэг өргөн хэрэглээний бараа үйлдвэрлэхэд харьцангуй давуу талтай байдаг. Харин өрнөдийн аж үйлдвэрийн талаар хөгжингүй улсууд өндөр мэргэшилтэй ажиллах гар шаардлагатай цоо шинэ төрлийн бүтээгдэхүүнийг санал болгох чадвартайгаараа давуу байдаг билээ. Ингэхлээр нэг талаас энгийн хөдөлмөр, нөгөө талаас маш өндөр мэргэшлийн хүний капитал хоёр оршин байгаа нь дэлхийн зах зээл дээр хуучин шинэ тоглогчдын хоорондын худалдааны урсгалын хөдөлгөөнийг тодорхойлж байна гэж Норман Бертольд онцлон тэмдэглэжээ .

Дэлхийн таваарын зах зээл дээр Хятадын гүйцэтгэх үүрэг эрчимтэй нэмэгдэж байгаа тухай мэдээ сүүлийн үед их гарах болов. Тухайлбал, 1980-1996 онд Хятадын экспорт 8 дахин өсч 18 тэрбум доллар байснаа 151 тэрбум доллар болтол өсчээ. /19/. Үүнтэй уялдуулан хэлэхэд Францын судлаач Ф.Лемуаны дэвшүүлсэн санаа сонирхол татна. Түүний гол санаа нь тухайн нэг орсон “дэлхийн худалдааны хөдөлгүүрүүдийн” нэг болж хувирах нь дотоодын шалтгааны төдийгүй бас “энэхүү урагшлах хүчирхэг хөдөлгөөнд гадаадын пүүсүүд чухал үүрэг гүйцэтгэх болсны ач юм гэдэгт оршино. Тухайлбал, гадаадын хөрөнгө оруулалт хийгээд Хятадын худалдааны хооронд “хуваарилагч” болсон Гонконгийн ач тусаар Хятад өнөөдөр тийм өндөрлөгт хүрэх боломжтой болжээ. Гонконгоор дамжин гадаадын хөрөнгө оруулалт Хятадад орохын зэрэгцээ Хятадын гадаад худалдааны эргэлтийн тэн хагас нь Гонконгоор дайрч гардаг. Дэлхий дахинд глобалчлалын үйл явц өрнөөгүй бол Хятад болон Зүүн Өмнөд Азийн аж үйлдвэрийн өндөр хөгжилтэй болсон шинэ улсууд эдийн засгийн хөгжилдөө тийм хүчтэй үсрэлт хийж чадах байсан нь юу л бол. Үүнтэй маргах судлаачид бараг гарахгүй биз ээ.

Глобалчлал нь даян дэлхийн хэмжээгээр бараа таваар, мөнгө солилцох үйл явц өргөжин идэвхжиж байгаагаар төдийгүй бас таваарын болон мөнгөний зах зээлд үйл ажиллагаа явуулагчид өөрсдөө ч өөрчлөгдөж байгаагаар илэрч байна. Хөрөнгө төвлөрч байгаагийн үр дүнд операториуд улам бүр хүчирхэг, том болж олон орны нутаг дэвсгэрт бизнес түгэн тархахын хэмжээгээр өөрсдийн зохион байгуулалтын болон удирдлагын бүдүүвчүүдийг өөрчилж байна. Тэд харилцаа холбооны, тээврийн, санхүүгийн зэрэг зохион байгуулалтын болон технологийн шижмүүдийг үйл ажиллагааныхаа орон зайд түгээн тархаж байна.

Худалдааны корпорациудын сүлжээний зэрэгцээ ястан үндэстний, шашны, террорист болон мафийн, тэрчлэн нүсэр том хотын мафийн сүлжээ ч бас оршиж байна. Эдгээр сүлжээ нь таваар, мөнгөний урсгалын зэрэгцээгээр үндэстнүүд ойртох, харилцан хамааралтай болох илрэлийг хүчтэй болгож байна.

Аяндаа болж буй глобалчлалын нэг зохисгүй жишээ нь мансууруулах бодисны үйлдвэрлэл, тээвэрлэлт, худалдааг дэлхий дахины хэмжээнд нэгтгэсэн мансууруулах бодисын бизнес юм. Мансууруулах бодисын бизнес нь улс үндэстэн, хил хязгаар гэж байхгүй дэлхийг хамарсан үзэгдэл болжээ. Тэр нь эрэлт нийлүүлэлтээр, демпингийн болон бартерын хуулиудаар зохицуулагдаж байна. Мансууруулах бодисын бизнес нь ХХ зууны төгсгөлийн үеийн аливаа

эрэлт гүйлгээ сайтай бүтээгдэхүүнийг үйлдвэрлэгчийн баримталдагтай адилхан стратеги тактикийг ашиглаж байна. Мансууруулах бодистой холбоотой бүхэн нь “орчин үеийн ч”, “уламжлалт ч”, “дэлхий нийтийн ч”, “бүс нутгийн ч” шинжийг нэгэн зэрэг агуулж байгаараа улам бүр их аюултай боллоо. Үүний эсрэг дэлхий дахинаараа тэмцсээр байгаа хэдий ч сайн жор олоогүй л байна. Түүний цаад уг сурвалж нь өнөө л өлсгөлөн, ядуурал, нийгмийн тэгш биш байдал аж.

Хятадын судлаач Х.Фаны тэмдэглэсэнчлэн “өрсөлдөөн хийгээд эдийн засагт зонхилох үүрэг гүйцэтгэхийн төлөө тэмцэл, хяналт хийгээд хариу хяналт, хориг хийгээд хариу хориг, хавчлага хийгээд сөрөг хавчлага нь” өдгөө нэгэнт олон улсын тэмцлийн үндсэн хэлбэр болон хувирчээ. Энэ улгаар авч үзвэл, өрсөлдөөн өргөжсөний дүнд “нутаг дэвсгэрт улсууд” “худалдаачин улсуудад” байраа тавьж өгч байна хэмээн нотолж байна./20/ Ийм өөрчлөлтийн мөн чанар нь нутаг дэвсгэрийнхээ хэмжээг өргөжүүлэхийг эрмэлзэгч улсууд өөр хоорондын “хүч хэрэглэх тоглоомоос” “аятай тааламжтай байх тоглоомонд” шилжиж байгаад оршино. Ийм байдалд шилжвэл эдийн засгийг өсгөх зорилт дэвшигддэг байна.

Шинжээчдийн үзэж байгаагаар, энэ зуун нь үндэстэн дамнасан улам бүр томоохон концерниуд, үндэстнээс дээгүүр институт байгууллагууд шинээр байгуулагдах тугийн дор өнгөрөх аж. . Глобалчлал нь дэлхийн эдийн засгийн хөгжлийн зонхилох хандлага болно. Учир нь дэлхий дахины хэмжээнд хөдөлмөрийн хуваарь өөрийн үр ашигтай чанарыг нотолсон юм.

Орчин үеийн мэдээллийн техник, харилцаа холбооны хэрэгслүүдэд эргэлтийн чанартай асар их дэвшил гарч, энэ явцад капитал, таваар, хүмүүс чөлөөтэй хөдөлгөөнд орсны ачаар глобалчлалын үйл явц амжилттай хөгжих бололцоотой төдийгүй зайлшгүй зүйл болов. Үүний цар хэмжээг харахад дэлхийн бөмбөрцөг бүхэлдээ “глобалчлагдсан тосгон” болон хувирч байгаа мэт сэтгэгдэл төрж байна. Гэхдээ энэхүү “тосгон”-д санаа амарлингуй суурьшихын арга ерөөс байхгүй. Гагцхүү “глобал тоглогчийн” хэмжээнд хүрч чадсан эдийн засаг л найдвартай оршин тогтнох баталгаатай. Түүнтэй үйл ажиллагаагаа уялдуулан зохицуулж чадсан хамтрагч ч нэгэн адил амьдрах найдвартай байх болно.

/Үргэлжлэл дараагийн дугаарт/

Ашигласан материал

1. Б. Баабар. Алтан гурвалжин, УБ., 2000, Л. Болд. Амьд явах амар, амьдрах хэцүү, УБ., 2000, П. Цагаан. Дэлхийн хөгжлийн чиг хандлага ба Монгол орны давхар даваа, УБ., 2000, Т. Намжим. Даяаршилт: ойлголт, хандлага, УБ., 2001, Монгол Улсын Гадаад Хэргийн Яамны Мэдээллийн товхимол №4, УБ., 2001 зэрэг болно.
2. 50 years Is Enough: US Network for Gloval Economic Justice or visit www.50years.org/
3. Council of Canadians or visit www.canadians.org/
4. Globalization Research Center or visit <http://www.cio.com/forums/global/>, David Suzuki Foundation or visit www.davidsuzuki.org/, Edmonds Institute or visit www.edmonds-institute.org/
5. International Forum on Globalization (IFG) or visit <http://www.ifg.org/>
6. Harward Business Review, №8, 1983.
7. К. Ohmae. The Bordless World: Power and Strategy in the Interlinked Economy, Fontana, 1995
8. Finance and Development, №2, 1999.
9. В. Badie. La fin des territoires. Paris, 1995
10. Singh K. Financial Globalization: New Challenges for Peoples' Movements, Corporate Watch // Globalization and Corporate Rule (www.corpwatch.org/)
11-19 Мировая Экономика и Международные Отношения(МЭМО)№10-11, 2000, №8, 2001 дугаарт нийтлэгдсэн материалуудыг ашиглав.
20. Проблемы Дальнего Востока, 1994, №5